

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Эрдэнэцогт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БНА-2020/10/СТА-ТТЗ**

<p>Цахим хуудас: <a href="mailto:Bayankhongor@audit.gov.mn">Bayankhongor@audit.gov.mn</a></p> <p>Баянхонгор хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга тэргүүлэх аудитор : Б.Мөнхбат</p> <p>Утас: 70442584 Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: А.Цээням</p> <p>Утас: 70442424 Цахим хаяг: <a href="mailto:tseenyama@audit.gov.mn">tseenyama@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Д.Цэцэгмаа</p> <p>Утас: Цахим хаяг:</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. Аудитын гэрчилгээ.....	4
2. Аудитын тайлан .....	6
2.1. Оршил .....	6
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	6
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	9
2.8.1 Мөнгөн хөрөнгө.....	9
2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт .....	9
2.8.3 Авлага .....	9
2.8.4 Урьдчилгаа .....	10
2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт .....	10
2.8.6 Бараа материал .....	10
2.8.7 Үндсэн хөрөнгө .....	11
2.8.8 Өр төлбөр .....	11
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	12
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	12
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	13
2.11. Шилэн дансны мэдээлэл .....	13
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	14
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	14
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	15
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	15
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	16
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	19

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	23
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	24
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	28
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	30

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

## 1. Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г ЭРДЭНЭЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГА Т  
Ц.ТӨМӨРБААТАР ТАНАА

2020.03.24 № 1/352

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

Г Аудитын гэрчилгээ Т

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2.3-д заасны дагуу Эрдэнэцогт сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Эрдэнэцогт сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрдэнэцогт сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020282

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Эрдэнэцогт сумын Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

Эрдэнэцогт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Ц.Төмөрбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Эрдэнэцогт сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэцогт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 19-өөс 2020 оны 03 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Д.Цэцэгмаа гүйцэтгэв.

Эрдэнэцогт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 2/55 тоот албан бичгээр ирүүлж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2020 оны 03 дугаар 05-нд ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

#### **2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрдэнэцогт сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу боловсруулагдсан байна.

Эрдэнэцогт сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын албанаас тус сумын төсөвт байгууллагуудад дотоод аудит хяналт шалгалт хийгээгүй байна.

#### **2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Эрдэнэцогт сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.0 хувь буюу 22,4 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2327,7 сая төгрөгийн 1.0 хувь буюу 23,3 сая төгрөгөөр тооцсон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

#### **2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа төсвийн байгууллага 6, тусгайн сан 2, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс ЗДТГ, ЭМТ, БНА-2020/10/СТА-ТТЗ

Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Соёлын төв, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж санал дүгнэлт өгөөгүй байна.

Аудитад хамрагдаж дүгнэлт гаргасан 3 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

**Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга**

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

Нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төлөвлөгөө харьяа байгууллагуудын нэгтгэлийн дүнгээс 11,8 сая төгрөгөөр зөрүүтэй байсныг ЭМТ-ийн төсвийн гүйцэтгэлийн аудитлагдсан тайланд залруулга хийлгэсэн

**Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага**

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар акт, албан шаардлага өгөгдөөгүй.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 74,9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Үүнд:

**Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга**

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 67,2 сая залруулга хийгдсэн байна. Үүнд:

Сая төгрөгөөр

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдааны дүн		Үүнээс: Залруулсан алдааны дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
1.Ерөнхий боловсролын сургууль	1	45,6	1	45,6
2.Цэцэрлэг	2	21,6	2	21,6
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>67,2</b>	<b>3</b>	<b>67,2</b>

**Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчил**

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд залруулагдаагүй дараах 7,7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрлээ. Зөрчлийн нэгтгэлийн дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу. Үүнд:

Сая төгрөгөөр

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1.ЭМТ	2	0,5	1	0,5			1	0,00
2.ЕБСургууль	6	7,2	2	3,6	1	3,1	3	0,5
3.Цэцэрлэг	2	0,00					2	0,00
<b>ДҮН</b>	<b>10</b>	<b>7,7</b>	<b>3</b>	<b>4,1</b>	<b>1</b>	<b>3,1</b>	<b>6</b>	<b>0,5</b>

## 2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

### 2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 154.5 сая, эцсийн үлдэгдэл 202,2 сая төгрөг болж, 47.7 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-	-
Төрийн сангийн дансанд байгаа бэлэн мөнгө	154.5	202.2	47.7	100.0
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-	-
Хадгаламж	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>154.5</b>	<b>202.2</b>	<b>47.7</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: Эрдэнэцогт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 202.2 сая байгаагаас ОНХСангийн харилцах дансанд 130.3 сая, сум хөгжүүлэх сангийн харилцах дансанд 54,6 сая, ОНХО-ын дансны үлдэгдэл 17.3 сая төгрөг тус тус байршиж байна.

Орон нутгийн ерөнхий орлогын дансанд оны эхэнд 6.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайланд хугацаанд татварын орлогын 40.4 сая төгрөг, санхүүгийн дэмжлэгээр 697.5 сая төгрөг тус тус төвлөрч, 733,3 сая төгрөгийн санхүүжилт олгож, төсөвт байгууллагууд 6.3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж, үлдэгдэл 17.3 сая төгрөг байна.

Замд яваа мөнгөн хөрөнгө, хадгаламжийн дансанд мөнгөн хөрөнгө байхгүй байна.

### 2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний, эцсийн үлдэгдэл байхгүй.

### 2.8.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 135.7 сая, эцсийн үлдэгдэл 130.6 сая төгрөг болж 5.1 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	2.4	1.9	-0.5
Төлбөртэй үйлчилгээний авлага			
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээлийн хүүгийн авлага			
Бусад авлага	3.6	2.1	-1.5
Зээлийн авлага	129.7	126.5	-3.2
<b>Дүн</b>	<b>135,7</b>	<b>130,5</b>	<b>-5,2</b>

*Эх сурвалж: Эрдэнэцогт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 45,6 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн зээлийн хугацаа хэтэрсэн чанаргүй зээлийн авлагын үлдэгдэл 45.6 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл:

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, бууралт
1.ОНХС	2,6	1,6	-1,0
2.Соёлын төв	0,5	0,1	-0,4
3.СХС	129,7	126,5	-3,2
4.Сумын ЗДТГ	0,5	0	-0,5
5.Сумын ИТХ	0,1	0,1	0,0
6.ЭМТ	0,5	0,0	-0,5
7.ЕБСургууль	1,3	1,3	0,0
8. Цэцэрлэг	0,5	1,0	1,0
<b>ДҮН</b>	<b>135,7</b>	<b>130,6</b>	<b>-5,1</b>

#### 2.8.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний, эцсийн үлдэгдэл байхгүй байна.

#### 2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын эхний, эцсийн үлдэгдэл байхгүй.

#### 2.8.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 236.6 сая, эцсийн үлдэгдэл 268.4 сая төгрөг болж, 31.8 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
1.Тусгай зориулалтын материал	30.4	30,4	0
2.Эм, ороох боох материал	0.2	1.0	0.8
3.Бичиг хэргийн материал	3.6	5.9	2.3
4.Аж ахуйн материал	180.4	214.2	33.8
5.Түлш, шатах тослох материал	0	0.02	0.02
6.Барилгын засварын материал	0	1.0	1.0
7.Хүнсний материал	6.2	5.6	-0.6
8.Бусад хангамжийн материал	2.5	5.4	2.9
9.Мал амьтад	13.1	4.8	-8.3
<b>Дүн</b>	<b>236,6</b>	<b>268,4</b>	<b>31,8</b>

*Эх сурвалж: Эрдэнэцогт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын үлдэгдэлд тайлант онд эм боох материал, бичиг хэргийн материал, аж ахуйн материал, түлш, шатах тослох материал, барилгын засварын материал, хангамжийн материал нийт 40.8 сая төгрөгөөр нэмэгдэж, 245.0 сая төгрөгийн бараа материалын худалдан авалт хийж, 224,8 сая төгрөгийн зарцуулалт гарсан, аж ахуйн материалын үлдэгдлийн өсөлтөд ЗДТГ-ын аж ахуйн материал тайлант онд 24.7 мянган төгрөгөөр нэмэгдэж 2.8 сая төгрөгөөр хасагдсан, Цэцэрлэг 6.1 сая төгрөгөөр, сургууль 3.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон ашиглагч байгууллагад шилжүүлээгүй бараа материалын дансанд бүртгэлтэй хөрөнгө байхгүй байна.

## 2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5182.9 сая, эцсийн үлдэгдэл 6454,5 сая төгрөг болж, 1271,7 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
1.Барилга байгууламж	4132.4	5382,3	1249,9
2.Тээврийн хэрэгсэл	183.7	191,9	8,2
3.Машин,тоног төхөөрөмж	530.5	507,3	-23,2
4.Тавилга, эд хогшил	215.0	245,6	30,6
5.Дуусаагүй барилга байгууламж	0	0	0
6.Номын фонд	32.2	37,2	1,2
7.Бусад үндсэн хөрөнгө	0	3.0	5,0
8.Программ хангамж	1,8	1,6	-0,2
9.Бусад биет бус хөрөнгө	87.3	87.6	0.2
<b>Дүн</b>	<b>5182.9</b>	<b>6454,5</b>	<b>1271,7</b>

*Эх сурвалж: Эрдэнэцогт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 75.9 сая, хандиваар 1.1 сая, бусад хөрөнгө оруулалтаар 1315.6 сая төгрөг нийт 1392.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Хасагдсан үндсэн хөрөнгө нийт 121.2 үүнээс акталсан 121.0 сая, балансаас баланст шилжүүлсэн 0.2 сая төгрөгийн хөрөнгийн өөрчлөлт гарсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон улсын комиссын актаар хүлээн авсан Эрдэнэцогт сумын ЗДТГ-ын шинэ байр байна.

## 2.8.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 3.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 2.1 сая төгрөг болж 1.5 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<b>Богино хугацаат өр төлбөр дүн</b>	<b>3.63</b>	<b>2.1</b>	<b>1.5</b>	
1.Ажиллагсадтай холбогдсон өглөг	3.2	0	-3.2	
2.Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.2	1.4	1.2	
3.Байгууллагад төлөх өглөг	0.2	0.7	0.5	
4.Хувь хүмүүст төлөх өглөг	0.03	0	0	
<b>Нийт дүн</b>	<b>3.63</b>	<b>2.1</b>	<b>-1.5</b>	<b>100,0</b>

*Эх сурвалж: Эрдэнэцогт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн оны эцсийн үлдэгдэл нь 2.1 сая төгрөг нь Цэцэрлэг дээр үүссэн өр төлбөр байна. Бараа үйлчилгээний өглөг 1.2 сая төгрөг, байгууллагад төлөх өглөг 0.5 сая төгрөгийн өр төлбөртэй байна.

## 2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4792,7 сая, эцсийн үлдэгдэл 5979,6 сая төгрөг болж, 1186,9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 31. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1589,0	1589,0	0,00	
Өмч /төрийн/ /ТӨҮГ/				
Өмч /хувийн/ /ТӨҮГ/				
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/				
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/				
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/				
Хуримтлагдсан үр дүн	1022,0	2226,2	1204,2	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2181,7	2164,4	-17,3	
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга				
<b>Дүн</b>	<b>4792,7</b>	<b>5979,6</b>	<b>1186,9</b>	

Эх сурвалж: Эрдэнэцогт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал данс 1186,9 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ЗДТГ-ын шинэ байр ашиглалтад орсонтой холбоотой тайлант оны үр дүн 1186,9 сая төгрөгөөр илэрхийлэгдсэнээс шалтгаалсан байна.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга гараагүй байна.

## 2.9 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Эрдэнэцогт сумын ИТХ-ын 2019 оны орон нутгийн төсөв батлах тухай 8/04 дугаар тогтоолоор тайлант онд 32,2 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 40,4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 125,5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Нийт орлогын дүн</b>	<b>32.2</b>	<b>40.4</b>	<b>-8.2</b>	<b>125.5</b>
Хувь хүний орлогын албан татвар	5.0	12.5	-7.5	249.4
Хөрөнгийн орлого	13.0	20.2	-7.2	155.2
Улсын тэмдэгтийн хураамж	3.0	1.3	1.7	41.7
Хог хаягдал	3.5	0.2	3.3	6.9
Бууны албан татвар	3.7	4.0	-0.3	107.0

Байгалийн нөөц ашигласны телбэр	2.2	0.7	1.5	32.7
Бусад татвар	300	180	120	60.0
Татварын бус орлого /торгууль/	1.5	1.4	0.08	125.5

Орон нутгийн орлогын төлөвлөгөө 8.2 сая төгрөгөөр давсан Хувь хүний орлогын албан татвар, Хадгаламжийн хүүгийн орлогын албан татварын орлого давсантай холбоотой байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 11 хөтөлбөрт зориулан 2345.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2179.1 сая төгрөгийг урсгал зардалд, 166.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зарлагаас тусгай зориулалтын шилжүүлгээр 1287.4 сая, орон нутгийн төсөв, санхүүгийн дэмжлэгээр 731,1 сая, ОНХС-гаас 76,2 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 42.6 сая, үйл ажиллагааны орлогоос 50,4 сая, өмнөх оны үлдэгдлээс 157,0 сая, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 0.6 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн болон орон нутгийн санхүүгийн дэмжлэгийг батлагдсан хэмжээнд нь бүрэн авч, үйл ажиллагааны орлогоос 71,7 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 30.9 сая төгрөгийн санхүүжилтийг авч зарцуулсан ба Нийгмийн даатгалын сангаас авах санхүүжилтийг 11.7 сая төгрөгөөр дутуу авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 0.6 сая төгрөг бүрдүүлж, төлөвлөгөөг 100% биелүүлж ажилласан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2156,5 сая төгрөг буюу 91,9 хувьтай буюу 188,8 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан нь Эрүүл мэнд нийгмийн даатгалын сангаас 11,7 сая төгрөгөөр дутуу санхүүжилт авсан, ОНХС-гийн төсөл хөтөлбөрт 166,3 сая зарцуулахаар батлагдсанаас 53,2 сая төгрөгийн ажил хийгдэж 113,1 сая төгрөгийн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй, СХС-гаас 115,4 сая төгрөгийн зээл олгохоор төсвийг баталж 57,4 сая төгрөгийг олгосон, төсвийн зарцуулаагүй үлдэгдлийн 6,2 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

**Нэмэлт төсөв:** Хандив тусламжаар 6 байгууллага 33.8 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Гадаадын төсөл хөтөлбөрөөс ямар нэгэн санхүүжилт аваагүй бөгөөд дээд шатны төсөв захирагчаас 33.8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч тавилга эд хогшлын зардалд 7.1 сая, бараа ажил үйлчилгээний бусад зардалд 11.2 сая төгрөг, цэцэрлэг тэтгэвэр тэтгэмжийн зардалд 1.4 сая төгрөг нийт 33.8 сая төгрөгийг зарцуулан ажилласан байна.

## 2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Байхгүй

## 2.11. Шилэн дансны мэдээлэл

Эрдэнэцогт сумын Засаг дарга нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 136 мэдээллийг хугацаанд нь, 18 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	13	13	11		2
2	Хагас жил	3	3	2	1	

3	Улирал бүр	2	8	8			
4	Сар бүр	5	60	55	5		
5	Тухай бүр	6	72	60	12		
	Нийт	29	156	136	18	2	

## 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид зөвлөмж өгөгдөөгүй.

## 2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрдэнэцогт сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрдэнэцогт сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-1А

#### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>526,857,127.24</b>	<b>601,244,163.90</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	154,528,306.59	202,173,163.26
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	154,528,306.59	202,173,163.26
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	154,528,306.59	202,173,163.26
31211	Төрийн сангийн харилцах	154,528,306.59	202,173,163.26
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	135,732,902.00	130,628,629.97
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,400,803.00	1,966,121.97
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	3,630,319.00	2,137,178.00
3351	Байгууллагаас авах авлага	3,630,319.00	2,137,178.00
<b>336</b>	<b>Зээлийн авлага</b>	129701780.00	126525330.00
<b>3361</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	129701780.00	126525330.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	129701780.00	126,525,330.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	236,595,918.65	268,442,370.67
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	30,662,849.00	31,430,437.00
35110	Тусгай зориулалттай материал	30,394,649.00	30,394,649.00
35130	Эм боох материал	268,200.00	1,035,788.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	192,842,569.65	232,189,433.67
35410	Бичиг хэргийн материал	3,674,700.00	5,976,510.00
35420	Аж ахуйн материал	180,446,521.25	214,229,512.25
35440	Түлш, шатах тослох материал		21,460.08
35450	Барилгын засварын материал		1,026,500.00
35460	Хүнсний материал	6,248,848.40	5,574,021.34
35470	Бусад хангамжийн материал	2,472,500.00	5,361,430.00
35600	Мал амьтад	13,090,500.00	4,822,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,269,454,862.69</b>	<b>5,380,402,544.35</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	4,269,454,862.69	5,380,402,544.35
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	4,181,597,612.97	5,292,619,627.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,132,380,668.38	5,382,274,968.38
39202	Хуримтлагдсан элэгдэл	(353,911,546.78)	(484,898,642.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	183,679,234.00	191,939,234.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(75,968,578.95)	(97,811,142.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	530,533,922.96	507,316,285.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	(367,966,971.90)	(370,086,499.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	215,039,133.96	245,574,780.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	(114,399,133.63)	(120,009,692.09)

39214	Бусад үндсэн хөрөнгө		3,000,000.00
39217	Ном	32,210,884.93	35,320,334.93
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>87,857,249.72</b>	<b>87,782,916.82</b>
39301	Програм хангамж	1,780,000.00	1,580,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,280,750.28)	(1,355,083.18)
39303	Бусад биет бус хөрөнгө	87358000.00	87,558,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>4,796,311,989.93</u></b>	<b><u>5,981,646,708.25</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>3,595,778.56</u></b>	<b><u>2,043,101.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,595,778.56</b>	<b>2,043,101.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>3,595,778.56</b>	<b>2,043,101.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,179,062.56	
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	197,800.00	1,362,800.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>218916.00</b>	<b>680301.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	187,000.00	680,301.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	31916.00	
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>4,792,716,211.37</u></b>	<b><u>5,979,603,607.25</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>4,792,716,211.37</b>	<b>5,979,603,607.25</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,588,966,540.66	1,588,966,540.66
51101	Өмч: - төрийн	1,588,966,540.66	1,588,966,540.66
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,021,984,989.90</b>	<b>2,226,191,879.54</b>
51210	Өмнөх үеийн үр дүн		1,039,304,483.66
51220	Тайлант үеийн үр дүн		1,186,887,395.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,181,764,680.81	2,164,445,187.05
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>4,796,311,989.93</u></b>	<b><u>5,981,646,708.25</u></b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

#### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,956,037,891.68</b>	<b>3,514,616,291.23</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>15,448,847.79</b>	<b>39,001,280.23</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	<b>6,884,910.79</b>	<b>32,651,180.23</b>
